



СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ,  
ЗАЛУУЧУУДЫН ЯАМ

## ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

**Хамрагдсан байгууллага:** СҮХБААТАР АЙМГИЙН ЖААХАН ШАРГА ТЕАТР  
**Тайлангийн код:** СХШУДАГ-2026/ДА/04

Улаанбаатар хот

2026 он

**агуулга**

АГУУЛГА .....	1
1. ТАНИЛЦУУЛГА.....	2
1.1. Байгууллагын тухай .....	2
2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ .....	3
2.1. Аудитын зорилго: .....	3
2.2. Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт .....	3
2.3. Аудитын арга, аргачлал .....	3
2.4. Өмнөх шалгалтын талаар .....	4
3. БАЙГУУЛЛАГЫН САЙН ТУРШЛАГА.....	4
3.1. Засаглалын удирдлагын талаар.....	5
3.2. Эрсдэлийн удирдлагын талаар .....	5
3.3. Дотоод хяналтын талаар.....	5
4. САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР .....	6
4.1. Төсөвт байгууллагын төрийн өмчийн бүртгэл, ашиглалт, зарцуулалт; .....	7
4.2. Төрийн аудитаас 2024 онд өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт; .....	8
4.3. Шилэн дансны тухай хуулийн 2025 оны хэрэгжилт; .....	9
4.4. Салбарын сайдын 2025 оны төсвийн багцаас харьяа байгууллагуудад олгосон үр дүнд суурилсан нэмэлт санхүүжилтийн зарцуулалт, үр дүнг .....	9
5. АУДИТЫН ҮР ДҮН .....	10
6. НЭГДСЭН ДҮГНЭЛТ .....	13

## 1. ТАНИЛЦУУЛГА


Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-д заасан “Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитыг хэрэгжүүлэх”, 69 дүгээр зүйлийн 69.3 “Дотоод аудитад төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагаа хамаарна”, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 7.2, 7.3, Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2026 оны 03 дугаар сарын 11-ны өдрийн А/101 дугаар тушаалаар баталсан “Сүхбаатар аймаг дахь харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, дотоод аудит хийх” удирдамжийн дагуу 2026 оны 03 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн СХШУДАГ-ын дарга Ч.Энх-Амгалан ахалж, тус газрын ахлах шинжээч Ц.Алтанхуяг, шинжээч Г.Шүрэндолгор Сүхбаатар аймгийн Жаахан шарга театрын үйл ажиллагаанд дотоод аудитыг гүйцэтгэлээ.

### 1.1. Байгууллагын тухай

Сүхбаатар аймгийн Жаахан Шарга театр нь 1942 он “Жаахан шарга” аймгийн клуб нэртэйгээр байгуулагдаж байсан ба 1958 онд Соёлын ордон, 1987 онд Хөгжимт драмын театр болж мэргэжлийн урлагийн байгууллага болох суурь тавигдаж одоог хүртэл ажиллаж “Угсаатны соёлын үнэт зүйлийн давтагдашгүй онцлогийг орчин үеийн дэвшилтэд ололтоор баяжуулан хөгжүүлсэн уран бүтээлийг мэргэжлийн түвшинд бүтээн туурвих, түгээн дэлгэрүүлэх, хүн амын оюун санаа, гоо зүйн хэрэгцээг хангахуйц уран бүтээл, үйлчилгээг үзэгчдэд хүргэх замаар соёл, урлагийн хөгжилд хувь нэмэр оруулахад оршино” хэмээн байгууллагын эрхэм зорилгоо тодорхойлж үйл ажиллагаагаа явуулж иржээ.

Тус театраас Ардын жүжигчин Ш.Чимэдцэеэ, гавьяат жүжигчин Б.Доржцэрэн, урлагын гавьяат зүтгэлтэн Л.Гомбосүрэн зэрэг олон алдартан төрөн гарсан байна.

Жаахан шарга театрын бүтэц



Тус байгууллага нь Аймгийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн А/188 дугаар захирамжаар бүтэц орон тоог 82 ажилтантай байхаар батлуулсан ба 2026

оны 03 дугаар сарын байдлаар 70 ажилтан, албан хаагчтай ажиллаж байна. Албан тушаалын ангилал зэрэглэлийн хувьд ТҮСБ-69, ТҮМ-2, ТҮ-2 ажилтан, албан хаагч байна. Нийт ажилтны 71%-ийг уран бүтээлчид 18%-ийг үйлдвэр үйлчилгээний ажилтан, 10%-ийг захиргааны ажилтан эзэлж байна.

Тус театрын барилга нь 2008 онд ашиглалтад орсон ба 547 хүний суудалтай үзвэрийн танхимтай. Театрын барилгын их засварт нийт 7,300.0 сая төгрөг батлагдсан ба 2026 оны улсын төсөвт 2,400.0 сая төгрөгийн их засвар хийх санхүүжилт батлагдсан байна. Их засварын гүйцэтгэчийг сонгон шалгаруулах ажиллагаа явагдаж байна.

Байгууллагын регистрийн дугаар 9052836, үндсэн үйл ажиллагааны 100120035020, орон нутгийн төсвөөс санхүүжих 100120035012 дугаар харилцах дансаар төлбөр тооцоог бэлэн бусаар хийж иржээ.

Аймгийн Засаг даргын 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн Б/54 дүгээр захирамжаар Х.Эрдэнэдэлгэрийг Жаахан шарга театрын даргын албан тушаалд томилсон байна. Аудитын хамрах хугацаанд дээрх шийдвэрийн дагуу нэгдүгээр гарын үсгийг Х.Эрдэнэдэлгэр, хоёрдугаар гарын үсгийг нягтлан бодогчоор 2017 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн Б/43 дугаар тушаалаар томилогдсон С.Болортунгалаг нар тус тус зурж хөрөнгө, мөнгийг захиран зарцуулжээ.

Тус байгууллага нь 2025 оны жилийн эцсийн санхүү, татвар, нийгмийн даатгалын тайлангуудыг хуулийн хугацаанд нь холбогдох байгууллагуудад гарган өгч баталгаажуулжээ.

## 2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ

### 2.1. Аудитын зорилго:

Тус байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйл явцын үр нөлөөтэй байдлыг үнэлж, төсөв санхүүгийн үйл ажиллагаанд санхүүгийн аудит хийн дүгнэж, илэрсэн алдаа дутагдлыг арилгуулах, зөвлөмж өгөх байдлаар байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зорилго баримтлан ажилласан.

### 2.2. Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт

Хамарсан хүрээ: Тус байгууллагын 2025 оны жилийн эцсийн байдлаар тасалбар болгон санхүүгийн үйл ажиллагаа (засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналт, төсөв, төсөвт байгууллагын төрийн өмчийн бүртгэл, ашиглалт, зарцуулалт, Төрийн аудитын газраас гүйцэтгэсэн санхүүгийн тайлангийн 2024 оны аудитын шийдвэрийн биелэлт, Шилэн дансны тухай хуулийн 2025 оны жилийн эцсийн хэрэгжилт, салбарын сайдын 2025 оны төсвийн багцаас харьяа байгууллагуудад олгосон үр дүнд суурилсан нэмэлт санхүүжилтийн зарцуулалтын тайлан, үр дүн)-нд байдалд санхүүгийн дотоод аудитыг гүйцэтгэсэн.

Хязгаарлалт: Дээр дурдсан хүрээгээр энэхүү дотоод аудитыг хязгаарласан болно.

### 2.3. Аудитын арга, аргачлал

Сангийн сайдын 2019 оны 268 дугаар тушаалаар баталсан “Улсын салбарын дотоод аудитын аргачлал”, Соёлын сайдын /хуучин нэрээр/ 2022 оны А/118 дугаар тушаалаар баталсан “Дотоод аудитыг гүйцэтгэх аргачлал”-ыг мөрдөж санхүүгийн аудитыг гүйцэтгэсэн болно.

Аудитад дараах хууль эрх зүйн актуудыг шалгуур болго. Үүнд:

- ✓ Төсвийн тухай хууль;
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай;

- ✓ Төрийн хяналт шалгалтын тухай хууль;
- ✓ Төрийн аудитын тухай хууль;
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- ✓ Шилэн дансны тухай хууль;
- ✓ Хөдөлмөрийн тухай хууль;
- ✓ Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль;
- ✓ Соёлын тухай хууль;
- ✓ Музейн тухай хууль;
- ✓ Соёлын өвийг хамгаалах тухай хууль;
- ✓ Нийгмийн даатгалын тухай хууль;
- ✓ Бусад холбогдох хууль тогтоомж, эрх зүйн акт.

#### 2.4. Өмнөх шалгалтын талаар

Аймгийн санхүүгийн хяналт, аудитын албаны шалгалтад хамрагдсан байдал

Сүхбаатар аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас 2024 онд төлөвлөгөөт дотоод аудитад 2022-2023 байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудит хийж 5 асуудлаар зөвлөмж өгсөн байна. Үүнд:

- ✓ Өрөө тасалгааны хүрэлцээ дутмаг;
- ✓ Барилга нь сантехникийн шугам, цахилгаан монтажийн бүрэн бүтэн байдал алдагдсан хөдөлмөрийн аюулгүй байдаг эрүүл ахуйн шаардлага хангахгүй, өвлийн улиралд хүйтэн
- ✓ Ажлын байрны тодорхойлолт байхгүй албан тушаалд ажилтан томилуулж ажиллуулсан;
- ✓ Мэргэжлийн боловсон хүчин, хүний нөөц дутмаг;
- ✓ Хөдөлмөрийн дотоод журмын зүйл заалт тодорхой бус.

Эдгээр асуудлуудыг хянан үзэхэд хэрэгжилт 60%-тай хэрэгжжээ.Цаашид хэрэгжилт хангалтгүй асуудал анхааран ажиллах шаардлагатай байна.

### 3.БАЙГУУЛЛАГЫН САЙН ТУРШЛАГА

Жаахан шарга теарт нь 2025 оны жилийн эцсийн байдлаар нийт 75 үзвэр арга хэмжээ зохион байгуулж, нийт 21544 хүнд хүрч үйлчилгээ үзүүлж, жилийн эцсийн байдлаар 125,622.2 мянган төгрөгийн орлого төвлөрүүлжээ. Үүнд:

1. Өөрийн үндсэн уран бүтээл 13 тоглосон байна. Тэдгээрийг дурдвал: Концертын бүтээл-4, уянгын драмын жүжиг-1, сэргээн тоглосон пластик жүжиг-1, хүүхдэд зориулсан драмын жүжиг-1, орчин үеийн бүжиг-1, аялан тоглолт-2, Франчайзингийн гэрээгээр нийлүүлсэн уран бүтээл-2, уран бүтээлчийн бие-1 даасан тоглолт, хандивын тоглолт 4 зохион байгуулсан ба нийт 5111 үзэгчид хүрч ажиллажээ. Эдгээр уран бүтээлийг 4834 хүүхдэд, хөгжлийн бэрхшээлтэй 54 иргэн үзэж сонирхжээ.

2. Бусад үзвэр арга хэмжээ нь 47 зохион байгуулжээ.Үүнд: Хамтарсан уралдаан тэмцээн - 4, дотоодын фестиваль-4, гадаад тоглолт, арга хэмжээнд-6, урлагийн боловсролын хөтөлбөрт-4 тус тус амжилтай оролцжээ.

Дотоод хамтын ажиллагааны хүрээнд Улсын драмын эрдмийн театр, Дуур бүжгийн эрдмийн театр, улсын Филармон, Монгол үндэсний телевизийн Соёл, урлагийн редакц, аймгийнхаа соёлын төвүүд, , зураач, уран бүтээлч Ж.Мөнхцэцэг, хөгжмийн зохиолч Х.Цэцэн, Д.Нямхүү, бүжиг дэглээч Н.Номин-Эрдэнэ, Тайвань улсыг бүжигчин Яаяа Чэнь нартай тус тус хамтран ажиллажээ. Мөн Үндэсний урлагийн их театрын бүжигчин, дэглээч

МУСТА Т.Энхболдтой хамтран бүжиг ангид мастер класс сургалт, Дарьгангын залуус бүжиг шинээр дэглэж, Төрийн шагналт, Монгол улсын соёлын гавьяат зүтгэлтэн Ш.Гүрбазартай хамтран Мэс драмын жүжгийг тогложээ.

### **3.1. Засаглалын удирдлагын талаар**

#### **Засаглах удирдлага:**

Байгууллагын даргыг аймгийн Засаг дарга томилж байна. Тайлант онд аймгийн Засаг даргаар байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллажээ. Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр 8 зорилтын хэмжээнд 34 арга хэмжээ төлөвлөгдсөн ба гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 91.3 хувьтай үнэлэгдсэн байна.

Сүхбаатар аймгийн Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газартай 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр 01 дугаар “Хамтран ажиллах гэрээ” байгуулж, тус гэрээнд заасан арга хэмжээний хүрээнд хамтран ажиллажээ. Тус гэрээний хавсралтаар Соёл, урлагийн 3 чиглэлийн 23 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгажээ. Гэрээний хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр тайлан гаргаж Сүхбаатар аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газарт хүргүүлсэн байна.

#### **Хөдөлмөрийн дотоод журмын талаар:**

Байгууллагын даргын 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн А/11 тушаалаар “Хөдөлмөрийн дотоод журам”-д нэмэлт өөрчлөлт оруулж шинэчлэн баталсан байна.

#### **Тушаал шийдвэрийн талаар:**

Тус байгууллага нь 2025 оны жилийн эцсийн байдлаар улирлын байдлаар үндсэн үйл ажиллагааны чиглэлээр “А” индексийн 31, боловсон хүчний чиглэлээр “Б” индексийн 74, нийт 105 тушаал төлөвлөж гаргасан байна.

Байгууллагын засаглалын талаар ажлын баримт АБ1002-оор 8 асуулга авч дотоод аудитын аргачлалд заасан 8 шалгуураар үнэлгээ хийхэд төлөвшил нь “Давтамжтай буюу 2-р түвшин”-нд байна.

### **3.2. Эрсдэлийн удирдлагын талаар**

Тус байгууллага нь эрсдэлээ тодорхойлж, үнэлдэггүй.

Байгууллагын эрсдэлийн удирдлагын үйл явцын талаар ажлын баримт АБ1003-аар 12 асуулга авч, дотоод аудитын аргачлалд заасан 8 шалгуураар үнэлгээ хийхэд төлөвшил нь “Эхлэлийн буюу 1-р түвшин”-нд байна.

### **3.3. Дотоод хяналтын талаар**

Тус байгууллага нь Дотоод хяналт шалгалт зохион байгуулах журмыг Жаахан шарга театрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/09 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаар баталжээ. Дотоод хяналт шалгалтын ажлын хэсгийг 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/10 дугаар тушаалаар шинэчлэн баталж дотоод хяналт төлөвлөгөө, тайланг боловсруулан хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүрэг болгосон байна.

Дотоод хяналтын ажлын бүрэлдэхүүн 2025 оны төлөвлөгөөг байгууллагын даргаар баталгаажуулаагүй, байгууллагын Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журмын 3.6-д “Дотоод хяналт шалгалтын нэгж хяналт шалгалтынхаа үр дүн, авсан арга хэмжээг улиралд 1-ээс доошгүй удаа захирлын зөвлөлөөр болон удирдлагын байгаар хэлэлцүүлэн, шаардлагатай бол шийдвэр гаргуулан хамт олонд мэдээлнэ” гэсний дагуу тайлагнаагүй

байна. Дотоод хяналт, шалгалтыг журамд заасны дагуу хангалттай хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Дотоод хяналтын үйл явцын талаар ажлын баримт АБ1004-өөр 8 асуулга авч дотоод аудитын аргачлалд заасан 4 чиглэлийн 13 шалгуураар үнэлгээ хийхэд төлөвшил нь “Эхлэлийн буюу 1-р түвшин”-нд байна.

#### 4. САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

##### Төсвийн төлөвлөлт

Байгууллагын 2025 оны төсвийн төслийг 3,428,380.29 мянган төгрөгөөр боловсруулан ССАЖЗЯ-нд хүргүүлсэн.

ССАЖЗЯ-аас тус байгууллагын 2025 оны төсвийг 2,727,531.1 мянган төгрөгөөр анх баталсан боловч 2025 оны 7 дугаар сард хийгдсэн төсвийн тодотголоор 2,747,529.4 мянган төгрөг болж 19,998.3 мянган төгрөгөөр буурсан байна.

Тус байгууллагын 2025 оны урсгал санхүүжилтэд улс, орон нутгийн төсвөөс 1 хөтөлбөр 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 3,069,063.1 мянган төгрөгийн төсөв батлагдсан.

- Үндсэн үйл ажиллагааны зардалд- 2,381,877.5 мянган төгрөг
- Уран бүтээл хийх-30,000.0 мянган төгрөг
- Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшууллын зардалд-115,304.6 мянган төгрөг
- Байр ашиглалтын зардалд-321,533.7 мянган төгрөг
- Үйл ажиллагааны орлого 152,000.0 мянган төгрөг
- Гүйцэтгэлд суурилсан санхүүжилт 68,347.3 мянган төгрөг

Тус байгууллагын 2025 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 2,722,313.76 мянган төгрөгөөр өмнөх оноос 88,031.63 мянган төгрөгөөр буюу 3,2 хувиар буурсан байна. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлангаар 5,073.5 мянган төгрөгийн өглөгтэй байна.

#### Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

*Хүснэгт 1 /мянган төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	-	-	-
Бараа материал	329,254.8	328,158.9	-1.1
Үндсэн хөрөнгө	2,481,090.6	2,394,154.7	-86,935.9
<b>Нийт хөрөнгө</b>	<b>2,810,345.4</b>	<b>2,722,313.7</b>	<b>88,031.7</b>
Богино хугацаат өр төлбөр	-	5,073.5	5,073.5
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,810,345.4	2,717,240.2	-93,105.2
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>2,810,345.4</b>	<b>2,722,313.7</b>	<b>-88,031.7</b>

Тайлант онд нийгмийн даатгал шимтгэлд 4,200.0 мянган төгрөг, хувь хүний орлогын албан татварт 873.5 мянган төгрөгийн өглөг үүссэн байна. Тус өглөг үүсэх шалтгаан нь оны эцэст ажилчдын үр дүнгийн урамшууллын санхүүжилт дутуу орж ирсэн ба ажилчдад тооцоолсон урамшууллыг бүүрэн олгосон байна. Тиймээс дутуу орж ирсэн санхүүжилтийн дүнгээр нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварыг төлөх боломжгүй нөхцөлийг үүсгэжээ.

#### 4.1. Төсөвт байгууллагын төрийн өмчийн бүртгэл, ашиглалт, зарцуулалт

##### Бараа материалын талаар:

Бараа материал 2025 оны эхэнд 329,254.79 мянган төгрөг, жилийн эцсийн байдлаар 328,158.99 мянган төгрөгийн үлдэгдэлтэй ба өмнөх оноос 1,095.0 мянган төгрөгөөр буурсан байна. Тайлант хугацаанд нийт 99,130.42 мянган төгрөгийн бараа материалын худалдан авсан болон хандиваар ирсэн бол 100,226.21 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулагдсан байна.

##### Бараа материал

Хүснэгт 3 (мянган төгрөг)

Д/д	Төрөл	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл	Эзлэх хувь
1	Бичиг хэргийн материал	248.00	5,196.80	4,959.80	485.00	0.15%
2	Аж ахуйн материал	40,159.12	59,882.12	57,486.67	42,554.3	13.0%
3	Шатахуун	-	1,457.90	1,507.90	-	0%
4	Тусгай зориулалтын материал	112,675.43	7,360.0	19,300.15	100,735.27	30.7%
5	Сэлбэг хэрэгсэл	588.00	255.00	255.00	588.00	0.18%
6	Бусад хангамжийн материал	175,584.23	15,667.12	7,455.20	183,796.15	56.0%
<b>Дүн</b>		<b>329,254.79</b>	<b>99,130.42</b>	<b>100,226.21</b>	<b>328,158.99</b>	<b>100%</b>

Нийт бараа материалын 87 хувийг тусгай зориулалтын материал болон бусад хангамжийн материал эзэлж байна, үлдсэн 13 хувийг бусад бараа материал эзэлж байна.

Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 98,330.42 мянган төгрөгийн бараа материалын худалдан авсан, 100,226.21 мянган төгрөгийн бараа материалыг шаардах хуудсаар, зарлагын баримт үйлдэж зарцуулан тайлагнасан байна.

##### Үндсэн хөрөнгийн талаар:

Үндсэн хөрөнгө 2025 оны эхэнд 3,117,113.65 мянган төгрөг, жилийн эцсийн байдлаар 3,079,478.50 мянган төгрөгийн үлдэгдэлтэй ба 37,635.14 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь тайлант хугацааны 66,813.9 мянган төгрөгийн үнэ бүхий үндсэн хөрөнгө орлогод авч, 104,449.04 мянган төгрөгийн хөрөнгийг зарлагадаж 153,749.74 мянган төгрөгийн цэвэр элэгдэл байгуулсантай холбоотой байна.

**Үндсэн хөрөнгө**

*Хүснэгт 4(мянган төгрөг)*

№	Дансны нэр	Эхний үлдэгдэл дүн	Орлогын дүн	Зарлагын дүн	Эцсийн үлдэгдэл дүн
1	Барилга, байгууламж, орон сууц	2,554,787.65	900.0	1,783.33	2,553,904.32
2	Машин тоног төхөөрөмж(компьютер)	351,970.42	44,913.90	78,552.38	318,331.94
3	Тавилга, аж ахуйн эд хогшил	89,706.58	5,300.00	21,368.33	73,638.25
4	Тээврийн хэрэгсэл	58,000.00	15,000.00	-	73,000.00
5	Бусад биет бус хөрөнгө	59,904.00	-	-	59,904.00
6	Программ хангамж	2,745.00	700.0	2,745.0	700.0
	<b>Нийт дүн</b>	<b>3,117,113.65</b>	<b>66,813.90</b>	<b>104,449.04</b>	<b>3,079,478.50</b>

Нийт хөрөнгийн 83 хувийг барилга,байгууламж эзэлж байна. Тайлант хугацаанд 15,000.0 мянган төгрөгөөр автомашин, 8,763.9 тоног төхөөрөмж худалдан авсан бол 5,000.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж хандиваар ирсэн байна.

**4.2 Төрийн аудитаас 2024 онд өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт**

Тус байгууллагын 2024, 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитад хамрагдаж “Өөрчлөлтгүй” дүгнэлт авсан байна. Аудитын дүнгээр 2024 онд 1,471.0 мянган төгрөгийн төлбөрийн акт-1, 4300.5 мянган албан шаардлага-1, зөвлөмж-2, 2025 онд 784.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт авсан байна.

Төрийн аудитаас байгууллагын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хянахад биелэлт 100 хувьтай байна.

**Төрийн аудитын 2024 оны шийдвэрийн хэрэгжилтийн дүн**

*Хүснэгт 5 (мянган төгрөг)*

№	Гаргасан шийдэл	Аудитын байгууллагын тогтоосон акт, албан шаардлага, зөвлөмжийн товч утга	Мөнгөн дүн	Биелсэн хувь
1	Төлбөрийн акт	Цалингийн урамшуулал, ур чадварын нэмэгдлийг 1 албан хаагчид илүү олгосон нь цалин хөлсний тооцоолол, хяналтын үйл ажиллагаа хангалтгүй байсантай холбоотой байна.төсвийн зардал үндэслэлгүйгээр нэмэгдэж, санхүүгийн сахилга бат алдагдах, цаашид төсвийн төлөвлөлт, зарцуулалтын ил тод, хариуцлагатай байдлыг хангах шаардлага үүсжээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.3 дахь заалттай нийцээгүй байна.	1,471.00	100

2	Албан шаардлага	Даргын Б/43 тоот тушаалаар 77 албан хаагчид шинэ жилийн бэлэгний мөнгө олгосон нь байгууллага алдагдалтай ажилласан үед урамшуулал олгож, төсвийн зардал үндэслэлгүйгээр нэмэгдэж, санхүүгийн сахилга бат алдагдах, цаашид төсвийн төлөвлөлт, зарцуулалтын ил тод, хариуцлагатай байдлыг хангах шаардлага үүсжээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 41 дүгээр зүйлийн 41.2.3 дахь заалттай нийцээгүй байна.	4,300.50	100
3	Зөвлөмж	Шилэн дансны мэдээллийн 171 төрөлд хамаарах мэдээнээс 23 мэдээг хугацаанд нь байршуулаагүй нь мэдээллийн бүрдүүлэлт, хяналт хангалтгүй байсантай холбоотой байна. Үүний улмаас мэдээллийн ил тод байдал алдагдаж, хууль, журмын хэрэгжилт хангагдаагүй бөгөөд олон нийтийн мэдээлэл авах эрх зөрчигдөх, байгууллагын санхүүгийн сахилга бат, хариуцлагад сөргөөр нөлөөлөх эрсдэл үүсжээ.	-	100
4	Зөвлөмж	Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 21 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байна.	-	100

Төрийн аудитаас Жаахан шарга театрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар “Томилолтоор ажилласан албан хаагчдад 784.0 мянган төгрөгийн унаа, хоолны хөнгөлөлтийг давхардуулан илүү олгосон” зөрчилд 2026 оны 05 дугаар сарын 15-ны дотор барагдуулах төлбөрийн актыг тогтоосон байна.

#### 4.3. Шилэн дансны тухай хуулийн 2025 оны хэрэгжилт

Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтын шилэн дансны цахим системд 2025 онд 24 нэр төрлийн 171 мэдээлэл оруулахаас 1 мэдээ хугацаа хоцроосон. Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр талбарт 7 тушаалаар нийт 12,453.0 мянган төгрөгийн зардал гарсан тушаал шийдвэрийг мэдээлээгүй байна.

#### 4.4. Салбарын сайдын 2025 оны төсвийн багцаас харьяа байгууллагуудад олгосон үр дүнд суурилсан нэмэлт санхүүжилтийн зарцуулалт, үр дүн

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн А/212 дугаар тушаалаар Сүхбаатар аймгийн салбарын 15 байгууллага нийт 176,408.8 мянган төгрөгийн үр дүнд суурилсан санхүүжилтийг авсан байна.

Үр дүнд суурилсан нэмэлт санхүүжилтийн дүн

Хүснэгт 6 (мянган төгрөг)

№	Байгууллагын нэр	2023 он	2024 он	2025 он
1	Уулбаян соёлын төв	6,971.0	5,697.0	10,123.0

2	Түвшинширээ соёлын төв	7,576.0	7,545.0	8,646.0
3	Түмэнцогт соёлын төв	7,432.0	7,906.0	8,290.0
4	Наран соёлын төв	7,031.0	7,910.0	8,076.0
5	Дарьганга соёлын төв	5,370.0	6,746.0	7,730.0
6	Баяндэлгэр соёлын төв	9,534.0	6,599.0	7,657.0
7	Мөнххаан соёлын төв	6,105.0	6,214.0	8,071.0
8	Сүхбаатар соёлын төв	8,899.0	7,358.0	7,149.0
9	Асгат соёлын төв	11,721.0	6,102.0	7,034.0
10	Халзан соёлын төв	3,876.0	6,538.0	6,564.0
11	Онгон соёлын төв	7,287.0	7,930.0	6,276.0
12	Эрдэнэцагаан соёлын төв	7,707.0	7,703.0	4,495.0
13	Жаахан шарга театр	42,345.0	66,183.0	68,347.0
14	Музей	20,280.0	17,505.0	14,771.0
15	Нийтийн номын сан	8,825.0	25,597.0	6,416.0
	<b>Нийт дүн</b>	<b>160,958.2</b>	<b>193,533.0</b>	<b>176,409.6</b>

Жаахан шарга театр үр дүнд суурилсан нэмэлт санхүүжилтийн дүнгээр 2023 онд 42,345.0 мянган төгрөг улсын хэмжээнд 19 дугаарт, 2024 онд 66,183.0 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт авч 7 дугаарт, 2025 онд 68,347.0 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт авч 26 дугаар жагссан байна. Үр дүнд суурилсан нэмэлт санхүүжилтийн хэмжээ сүүлийн 3 жилийн хэмжээнд өссөн байна.

Жаахан шарга театр нь 2025 онд 68,347.0 мянган төгрөгийн үр дүнд суурилсан нэмэлт санхүүжилтээр журмын дагуу 20,500.0 мянган төгрөгийг уран бүтээлд, 27,338.7 мянган төгрөгийг хөрөнгө оруулалтад, 10,252.0 мянган төгрөгийг ажилтан албан хаагчдын нийгмийн баталгаанд, 10,252.1 мянган төгрөгийг ажилтаны урамшуулалд зарцуулсан байна.

Үр дүнд суурилсан нэмэлт санхүүжилтийн хөрөнгө оруулалтын чиглэлээр зарцуулсан 27,338.7 мянган төгрөгөөр автомашин, тайзны гэрэлтүүлэг, хулдаас, угаалгын машин, тоос торогч, оффесийн ажилтнуудад компьютер, принтер, проектор эзргийг авсан ажилтны ажиллах орчин сайжирхад нөлөөлжээ.

## 5. АУДИТЫН ҮР ДҮН

<b>Илэрсэн асуудал 1.</b>	Төрийн сангийн үйл ажиллагааны журмыг мөрдөж ажиллахгүй буюу бэлэн мөнгөөр 24,055.0 мянган төгрөгийн орлого хүлээн авч төвлөрүүлсэн байна.
<b>Асуудлын ангилал</b>	Нөлөө ихтэй
<b>Бодит байдал:</b> Үндсэн үйл ажиллагааны урлагийн тоглолтын орлого болон үндсэн бус үйл ажиллагааны орлого нийт 29,625.0 мянган төгрөг орлогыг бэлнээр хүлээн авч төвлөрүүлсэн. Үүнээс хөдөө орон нутагт тоглолт хийсэн орлого 5,570.0 мянган төгрөг байна. Жижиг мөнгөн сангийн дансгүй, бэлнээр хүлээн авч журмын дагуу зарцуулалтын тайлан гаргаагүй.	

<p><b>Шалгуур үзүүлэлт:</b> Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх” Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 3.6.1 "Төсвийн байгууллага нь Төсвийн тухай хуулийн 35.6-д заасан санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Монгол банктай хамтран баталсан журмын дагуу бэлэн мөнгө зарцуулах зориулалттай картын данстай байж болно", 3.6.2 "Төсвийн байгууллага нь энэ журмын 3.6.1-д заасан картын дансанд зөвхөн төрийн сангийн бүртгэлийн данснаас зөвшөөрөгдсөн төлбөрийг шилжүүлэн авч, зориулалтын дагуу зарцуулна", 3.6.6 "Төсвийн байгууллага нь төрийн сангийн бүртгэлийн данснаас зөвхөн бэлэн мөнгөний үйлчилгээ авах зорилгоор ЖМС-г картын дансандаа шилжүүлэн авна"; 3.6.10 "Төсвийн байгууллага нь мөнгөн касстаа бэлнээр хүлээн авсан үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогыг шууд захиран зарцуулах эрхгүй бөгөөд ажлын дараагийн өдөрт багтаан төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана" 3.6.8. "Төсвийн байгууллага нь ЖМС-ийн хөрөнгийн зарцуулалтын тайланг энэ журмын 6 дугаар хавсралтад заасан маягтын дагуу гарган картын дансны дэлгэрэнгүй хуулга, холбогдох үндэслэх баримтын хамт харьяа төрийн санд хүргүүлэн дараагийн ЖМС авах эрхээ нээлгэж болно".</p>
<p><b>Асуудлын үндсэн шалтгаан:</b> Төрийн сангийн үйл ажиллагааны журмыг мөрдөж ажиллахгүй байна.</p>
<p><b>Байгууллагад үзүүлэх нөлөө:</b> Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй үйлдэл, эс үйлдэл нь орлого дутуу төвлөрүүлэх, хувьдаа завших нөхцөл бүрдэх зэрэг зөрчил, дутагдал үүсэх эрсдэлтэй.</p>
<p><b>Зөвлөмж:</b> Төрийн сангийн үйл ажиллагааны журмыг мөрдөж ЖМС-ын данс нээлгэн үндсэн үйл ажиллагаандаа ашиглах, журамд заасны дагуу тайлагнах, цаашид үндсэн үйл ажиллагаанаас олсон орлогыг бэлнээр хураан авч төвлөрүүлэхгүй байх зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байхад анхаарч арга хэмжээ авч ажиллах.</p>

<b>Илэрсэн асуудал 2.</b>	Ажил гүйцэтгэх 24 гэрээгээр нийт 57,410.0 мянган төгрөгийн зардал гаргасан. Ажил гүйцэтгэх гэрээг дүгнээгүй, тайлан байхгүй байна.
<b>Асуудлын ангилал</b>	Нөлөө ихтэй
<p><b>Бодит байдал:</b> Жаахан шарга театр нь тайлант онд нийт 57,410.0 мянган төгрөгийн 24ш “Ажил гүйцэтгэх гэрээ”-ээр зардал гаргасан. Ажил гүйцэтгэх гэрээг дүгнэж акт үйлдээгүй тухайн ажил хийгдсэн эсэх талаар тайлан байхгүй буюу санхүүгийн анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллахгүй байна.</p>	
<p><b>Шалгуур үзүүлэлт:</b> Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн Төсвийн шууд захирагч, түүний бүрэн эрх 16 дугаар зүйлийн 16.5.1 "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.2 “батлагдсан төсөв хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад хяналт тавих”; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 3.1.3."анхан шатны баримт" гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог” гэсэн заалтай тус тус нийцэхгүй байна.</p>	
<p><b>Асуудлын үндсэн шалтгаан:</b> Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааны дотоод хяналт сул байна.</p>	
<p><b>Байгууллагад үзүүлэх нөлөө:</b> Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй үйлдэл, эс үйлдэл нь байгууллага зөрчил, дутагдал үүсэх эрсдэлтэй.</p>	
<p><b>Зөвлөмж:</b> Гэрээнд заасан эрх үүргээ хэрэгжүүлж гэрээг дүгнэж санхүүгийн анхан шатны баримтыг бүрдлийг хангаж ажиллах.</p>	

<b>Илэрсэн асуудал 3</b>	Өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэргүй нийт 24,513.9 мянган төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгасан.
<b>Асуудлын ангилал</b>	Нөлөө багатай
<b>Бодит байдал:</b> Шинээр худалдан авсан болон хандиваар ирсэн нийт 24,513.9 мянган төгрөгийн хөрөнгийг өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэр, данс бүртгэл тусгах тушаалгүйгээр хөрөнгийн данс бүртгэлд тусгасан байна.	
<b>Шалгуур үзүүлэлт:</b> Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх”, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 65 дугаар тогтоолын хавсралт “Төрийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын 5.2 Төрийн өмчит хуулийн этгээдийн удирдлага нь өмч хамгаалах байнгын зөвлөлийн зөвлөмж, дүгнэлтийг үндэслэн эд хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах, шилжүүлэх, акталж данснаас хасах санал хүргүүлэхээр шийдвэрлэсэн тохиолдолд зөвлөл нь дор дурдсан шаардлагыг хангаж, төрийн өмчийн асуудал эрхэлсэн байгууллагад хүсэлтийг хүргүүлэх ажлыг зохион байгуулна” заалтуудад нийцээгүй байна.	
<b>Асуудлын үндсэн шалтгаан:</b> Батлагдсан дүрэм журмыг үйл ажиллагаандаа мөрдөөгүй. Санхүүгийн дотоод хяналт хангалтгүй байна.	
<b>Байгууллагад үзүүлэх нөлөө:</b> Хууль, дүрэм журам зөрчигдөх. Хяналт шалгалтаар зөрчил, алдаа, дутагдал үүсэх эрсдэл үүснэ.	
<b>Зөвлөмж:</b> “Өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын дагуу байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлын шийдвэрийг гаргуулан, данс бүртгэлд тусгах тушаал шийдвэр гарган хөрөнгийг данс бүртгэлд бүртгэж байх.	

<b>Илэрсэн асуудал 4.</b>	Шилэн дансны цахим хуудсанд 12,453.0 мянган төгрөгийн 7 мэдээллийг мэдээлээгүй байна.
<b>Асуудлын ангилал</b>	Нөлөө багатай
<b>Бодит байдал:</b> Шилэн дансны цахим системд 2025 онд 24 нэр төрлийн 171 мэдээлэл оруулахаас 1 мэдээ хугацаа хоцроосон. Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр талбарт 7 тушаалаар нийт 12,453.0 мянган төгрөгийн зардал гарсан тушаал шийдвэрийг мэдээлээгүй байна.	
<b>Шалгуур үзүүлэлт:</b> Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйл "Шилэн дансны зарчим" 4.1.3 дахь заалт "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэнтэй нийцэхгүй байна.	
<b>Асуудлын үндсэн шалтгаан:</b> Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл байршуулах аргачлал, зааврыг бүрэн хэрэгжүүлээгүй үйлдэл, эс үйлдэл.	
<b>Байгууллагад үзүүлэх нөлөө:</b> Нийтийн мэдээллийн ил тод байдлыг хангах тухай, Шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдахгүй болох эрсдэлтэй.	
<b>Зөвлөмж:</b> Зөрчлийг давтан гаргахгүй байх. Шилэн дансны тухай хуулийн мэдээллийг хуульд заасан хугацаанд үнэн зөв, бодитой, иж бүрэн мэдээлж байх	

## 6.НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Сүхбаатар аймгийн Жаахан шарга театрын 2025 оны жилийн эцсийн байдлаарх төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд илэрсэн алдаа, дутагдлын үр нөлөө, цаашид үүсэх эрсдэлийг үнэлэн аудитаар илэрсэн асуудлын 75% нь нөлөө ихтэй байгаа учир **“Сайжруулах шаардлагатай”** гэсэн дүгнэлтийг өгч байна.

Цаашид аудитаар илэрсэн алдаа дутагдалыг залруулах, аудитын тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллаж, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 25-ны дотор СХШҮДАГ-т албан бичгээр нотлох баримтын хамт ирүүлэхийг мэдэгдье.

СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ЯАМ

---oOo--